MONGOLIAN RAILWAY

KOREA NATIONAL RAILWAY

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

БОЛОН

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЯАМНЫ БУС СТАТУСТАЙ УЛСЫН САЛБАРЫН БАЙГУУЛЛАГА БОЛОХ
“СОЛОНГОСЫН ҮНДЭСНИЙ ТӨМӨР ЗАМ” ЫН
ХООРОНД БАЙГУУЛАХ

# ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ДОХИОЛОЛ ХОЛБООНЫ СИСТЕМИЙН ЗУРАГ ТӨСӨЛ, ПРОГРАММ ХАНГАМЖ БОЛОВСРУУЛАХ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ, УГСРАЛТ СУУРИЛУУЛАЛТЫН ЦОГЦ АЖЛЫН ГЭРЭЭ

Улаанбаатар хот 2021 он

# ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ДОХИОЛОЛ ХОЛБООНЫ СИСТЕМИЙН ЗУРАГ ТӨСӨЛ, ПРОГРАММ ХАНГАМЖ БОЛОВСРУУЛАХ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ, УГСРАЛТ СУУРИЛУУЛАЛТЫН ЦОГЦ АЖЛЫН ГЭРЭЭ

2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр | Дугаар: СГ-21/110-109/05 | Улаанбаатар хот

ЭНЭХҮҮ ГЭРЭЭГ: Нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан төрийн өмчит хувьцаат компани болох “Монголын төмөр зам” ТӨХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал О.Батнасан,

Нөгөө талаас Бүгд Найрамдах Солонгос улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Ямны бус статустай улсын салбарын байгууллага болох “Солонгосын үндэсний төмөр зам”, түүнийг төлөөлж тус байгууллагын Монгол дахь салбарын захирал Ким Сон Юнг (Kim Seong Ryong) нар, (цаашид хамтад нь “Талууд” гэх) нар Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн бусад актыг удирдлага болгон 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр Улаанбаатар хотноо байгуулав.

## ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

1. Монгол Улсын “Монголын төмөр зам” ТӨХК (цаашид “МТЗ” ТӨХК гэх) болон Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам” (цаашид “УБТЗ” ХНН гэх) -ийн хооронд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд бүтэц, дохиолол холбоо, эрчим хүч, гүүр, хоолойн барилгын ажил, зураг төсөл гүйцэтгэх АГГ-20/21-20/06 дугаарын гэрээ (цаашид “Ерөнхий гэрээ” гэх)-г 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдөр байгуулагдсаныг;

2. “МТЗ” ТӨХК нь дээрх АГГ-20/21-20/06 болон ОГ/20/042 дугаартай гэрээний 2.1.3.1 дэх заалтаар “Дохиолол холбооны системийн зураг төсөл, программ хангамж боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт суурилалт гүйцэтгэх багц ажил” (цаашид “Дохиолол холбооны багц ажил” гэх) -ыг “УБТЗ” ХНН-ээр гүйцэтгүүлэхээр тохиролцсон ба захиалагч нь “МТЗ” ТӨХК (цаашид “Захиалагч” гэх), гүйцэтгэгч нь “УБТЗ” ХНН (цаашид “Ерөнхий гүйцэтгэгч” гэх) болохыг;

3. “УБТЗ” ХНН нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн “Дохиолол холбооны багц ажил”-ыг гүйцэтгүүлэх туслан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг гүйцэтгэж, БНСУ-ын “Солонгосын үндэсний төмөр зам” байгууллагыг сонгон шалгаруулан, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд зохион байгуулах худалдан авах ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих чиг үүрэгтэйгээр Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 дугаар тушаалаар байгуулагдсан Дэд ажлын хэсэг (цаашид “Дэд ажлын хэсэг” гэх)-т санал болгосныг;

4. “УБТЗ” ХХН-ийн саналыг Дэд ажлын хэсгийн 2020 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 153 дугаарын зөвлөмжөөр дэмжиж, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын

төслийн "Дохиолол холбооны багц ажил"-ыг "Солонгосын үндэсний төмөр зам" (Korea National Railway) байгууллагаар гүйцэтгүүлэх, багц ажлын үнийг 121,587,141,223 (нэг зуун хорин нэгэн тэрбум, таван зуун наян долоон сая нэг зуун дөчин нэгэн мянга хоёр зуун хорин гурван) төгрөгөөр тогтоож, тухайн компанитай холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ байгуулах, гэрээ байгуулахдаа ажлын төлбөрийг гүйцэтгэлээр санхүүжүүлэх болон банкны баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөр олгох асуудлыг гэрээнд тусгах зөвлөмжийг "МТЗ" ТӨХК болон "УБТЗ" ХНН-д ирүүлсэнийг;

5. "Солонгосын үндэсний төмөр зам" байгууллага нь (цаашид "Туслан гүйцэтгэгч" гэх) нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн "Дохиолол холбооны багц ажил"-ыг гүйцэтгэхдээ БНСУ-ын "Byuksan power Co., Ltd" компани (цаашид "Түншлэгч" гэх)- тай түншлэн гүйцэтгэхээр тохиролцсон ба эдгээр талуудын хооронд 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Түншлэлийн гэрээ байгуулагдсаныг;

6. "Дохиолол холбооны багц ажил"-ын хүрээнд Захиалагчаас урьдчилгаа төлбөр хийгдэхээр бол Түншлэгч нь баталгаат даатгалын гэрчилгээг Захиалагчид гаргаж өгөхөөр Түншлэлийн гэрээнд тусгагдсан ба баталгаат даатгалын гэрчилгээ нь банкны баталгаатай дүйцэхүйц бичиг баримт болохыг;

7. Ерөнхии гүйцэтгэгч нь Туслан гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээг бие дааж тусдаа байгуулсны үндсэн дээр "Дохиолол холбооны багц ажил"-ыг удирдан гүйцэтгүүлэх ба энэ нь Ерөнхий гэрээний 2.1.3.1 дэх заалтын дагуу Ерөнхий гүйцэтгэгчийн Захиалагчийн өмнө бүрэн хүлээсэн үүрэг болгосныг;

8. Ерөнхий гүйцэтгэгчийн Туслан гүйцэтгэгчтэй байгуулах дээрх гэрээний нөхцөл, ажлын үе шат, ажлын гүйцэтгэлд тулгуурлан Захиалагч нь "Дохиолол холбооны багц ажил"-ын төлбөрийг Туслан гүйцэтгэгчид шууд төлж барагдуулахаар талууд тохиролцсоныг;

9. "Дохиолол холбооны цогц ажил"-ын хүрээнд Туслан гүйцэтгэгчийн зохион явуулах сургалтын үйлчилгээ болон чанарын баталгаат хугацаанд үзүүлэх засвар үйлчилгээний ажил нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын ашиглалтын дараах үйл ажиллагааг дэмжих, салшгүй холбоотой үйл ажиллагаа тул энэхүү гэрээнд тусгаж зохицуулах нь Захиалагчийн эрх ашигт нийцсэн үйлдэл болохыг;

10. Энэхүү гэрээг байгуулж, гарын үсэг зурах эрх "МТЗ" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал О.Батнасанд "МТЗ" ТӨХК-ийн дүрмийн 8.4-д зааснаар олгогдсон болохыг;

11. Энэхүү гэрээг байгуулж, гарын үсэг зурах эрх "Солонгосын үндэсний төмөр зам" байгууллага нь Монгол дахь салбарын захирал Ким Сон Юнг (Kim Seong Ryong) –д 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр итгэмжлэлээр олгогдсон болохыг;

12. "МТЗ" ТӨХК нь Монгол Улсын төмөр замын салбарт улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр үүссэн өмчийг эзэмших, ашиглах, төмөр замын салбарт үндэсний компани бий болгох зорилгоор 2008 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 82 дугаар тогтоол, мөн сарын 20-ны өдрийн Төрийн өмчийн хорооны шийдвэрээр үүсгэн байгуулагдсан, Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлд улсын бүртгэлийн 9012001025, регистрийн 5214203 дугаартайгаар бүртгэгдсэн төрийн өмчит хувьцаат компани болохыг;

13. "Солонгосын үндэсний төмөр зам" байгууллага нь БНСУ-ын Төмөр замын аж үйлдвэрийн хөгжлийн тогтолцооны хууль, Төмөр замын сүлжээний удирдах газрын тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Газар, дэд бүтэц, тээврийн яамны харьяа төмөр замын дэд бүтцийг барих, удирдах зорилготой яамны бус статустай улсын байгууллага, БНСУ-ын хуулийн этгээдийн улсын бүртгэлд 305-82-13158 дугаараар бүртгэгдсэн гэрчилгээтэй

хуулийн этгээд болохыг тус тус тэмдэглэн Гэрээний Талууд дараах зүйлийг харилцан тохиролцов.

## 1. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

1.1 Энэхүү гэрээгээр:

1.1.1 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн “Дохиолол холбооны багц ажил”-ын гэрээний үнийг;

1.1.2 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн “Дохиолол холбооны багц ажил”-ын гэрээний төлбөрийн нөхцөлийг;

1.1.3 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн “Дохиолол холбооны багц ажил”-ын хүрээнд хийгдэх сургалт, дадлагажуулалтын ажлын талаар;

1.1.4 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн “Дохиолол холбооны багц ажил”-ын хүрээнд хийгдэх чанарын баталгаат хугацаанд засвар үйлчилгээ үзүүлэх асуудлыг тус тус харилцан тохиролцоно.

## 2. ГЭРЭЭНИЙ ҮНЭ

2.1 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн “Дохиолол холбооны багц ажил”-ын гэрээний үнэ (цаашид “Гэрээний үнэ” гэх) 121,587,141,223 (нэг зуун хорин нэгэн тэрбум, таван зуун наян долоон сая нэг зуун дөчин нэгэн мянга хоёр зуун хорин гурван) төгрөг байна.

2.2 Туслан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад ам.доллараар өгсөн үнийн саналыг тухайн өдөр буюу 2020.08.19-ны өдрийн Монгол банкны ам.долларыг төгрөгт шилжүүлэх хаалтын ханш болох 2849.35 төгрөгөөр тооцон төгрөгт хөрвүүлсэн ба энэ ханшийг цаашдаа тогтмол мөрдөж, ам.долларын ханшийн өсөлт, бууралт гэрээний үнэд нөлөөлөхгүй гэдгийг Талууд харилцан тохиролцсон болно.

2.3 Гэрээний үнэд “Дохиолол холбооны багц ажил”-д хэрэглэгдэх бүх эд анги, тоног төхөөрөмж, холбох хэрэгсэл (интерфейс), тоног төхөөрөмжийн худалдан авалт, нийлүүлэлт, тэдгээрийг суурилуулах, барилгын угсралт, туршилтын ажил, бараа материалын үнэ, ажлын хөлс, тээврийн зардал, ачих буулгах зардал, тоног төхөөрөмжийн буурршгүй нөөцийн болон гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох бүхий л зардал, үйлдвэрийн туршилт, мэргэшүүлэх болон дадлагажуулах сургалтын /гадаад болон дотоод/ зардал болон чанарын баталгаат хугацаанд засвар үйлчилгээ үзүүлэх бүхий л зардал багтсан болно.

2.4 Гэрээний хэрэгжилтийн явцад шинээр батлагдсан хууль, төрийн аливаа шийдвэрүүдэд нэмэлт болон өөрчлөлт орсон нь гэрээний үнэд өөрчлөлт орох үндэслэл болохгүй.

2.5 Гэрээний үнээс 16,316,888,256 (арван зургаан тэрбум гурван зуун арван зургаан сая найман зуун наян найман мянга хоёр зуун тавин зургаан) төгрөгийг Захиалагч нь суутган авч үлдэх ба энэ нь “Дохиолол холбооны багц ажил”-ын хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн импортын гаалийн болон НӨАТ-ын төлбөр, захиалагчийн хяналтын болон удирдлагын зардал болно.

2.6 Дээрх тохиролцооны дагуу “Дохиолол холбооны багц ажил”-ын хүрээнд импортоор нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, техник хэрэгслийг Туслан гүйцэтгэгч нь Захиалагчийн

нэр дээр буюу “МТЗ” ТӨХК гэсэн хүлээн авагч байхаар ачуулж тээвэрлүүлнэ.

2.7 Гэрээний үнээс үлдэх 105,270,252,967 (нэг зуун таван тэрбум хоёр зуун далан сая хоёр зуун тавин хоёр мянга есөн зуун жаран долоон) төгрөгийг энэхүү гэрээний 3 дугаар бүлэгт заасны дагуу Туслан гүйцэтгэгчид төлж барагдуулна. Энэ төлбөрт энэхүү гэрээний 2.3 дахь заалтад дурдсан бүхий л зардал багтсанаас гадна Туслан гүйцэтгэгчийн Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу төлбөл зохих татвар, хураамж, бусад төлбөр багтсан ба зөвхөн импортын гаалийн болон НӨАТ ороогүй болно. Гэрээт ажлын хүрээнд энэхүү гэрээний 2.3 дахь заалтад дурдагдаагүй нэмэлт зардал гарвал түүнийг Туслан гүйцэтгэгч өөрөө хариуцна.

## 3. ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨР

3.1 Ерөнхий гүйцэтгэгч болон Туслан гүйцэтгэгчийн хооронд байгуулах “Дохиолол холбооны системийн зураг төсөл, программ хангамж боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт суурилалт гүйцэтгэх багц ажил гүйцэтгэх гэрээ” (цаашид “Ажил гүйцэтгэх гэрээ” гэх) болон тус гэрээний үе шатны ажлын гүйцэтгэлийг Захиалагч болон Ерөнхий гүйцэтгэгч дүгнэж, төлбөр хийгдэхийг зөвшөөрсөн баримт бичиг (цаашид “хянан баталгаажуулсан акт” гэх) нь Захиалагчаас Туслан гүйцэтгэгчид төлж барагдуулах төлбөрийн үндэслэх баримт бичиг болох ба энэхүү гэрээний салшгүй хэсэг болно. Хянан баталгаажуулсан актыг Ерөнхий гүйцэтгэгч ирүүлж, Захиалагч хянан баталгаажуулсны үндсэн дээр төлбөр төлөгдөнө.

3.2 “Дохиолол холбооны багц ажил”–ын хүрээнд импортоор нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, техник хэрэгслийг тодорхойлж, үйлдвэрт захиалж үйлдвэрлүүлэн, Монгол Улс руу ачуулах үе шатны ажлын зардалд урьдчилгаа төлбөр (цаашид “Урьдчилгаа төлбөр” гэх) төлөхөөр Талууд тохиролцсон болно.

3.3 Туслан гүйцэтгэгч нь банкны баталгаатай дүйцэхүйц хэлбэрийн баталгааг Захиалагчид ирүүлсний үндсэн дээр Урьдчилгаа төлбөр хийгдэнэ.

3.4 Урьдчилгаа төлбөрийг Туслан гүйцэтгэгчийн Ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулах Ажил гүйцэтгэх гэрээнд тусгагдсан ажлын хуваарьт нийцүүлэн төлөх ба энэ нь ажлын үе шат бүрээр дараах байдалтай байна. Үүнд:

| Д/д | Үе шат бүрээр ажил дуусах огноо | Үе шатны ажил | Төлбөрийн хэмжээ /төгрөг/ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | 2021-09-24 | Гэрээлэх болон ажил эхлэх | | |
| 2 | 2021-10-14 | Гол бараа материал нийлүүлэх жагсаалтыг бэлтгэж бэлэн болгосон байх | 10 тэрбум төгрөг | Гэрээний 3.1 ба 3.3 заалт хангагдсан байх |
| 3 | 2021-11-24 | Гол бараа материал нийлүүлэх жагсаалтыг батлуулсан байх | 8 тэрбум төгрөг | |
| 4 | 2021-12-31 | Гол бараа материал үйлдвэрлэлд захиалагдсан байх | 18 тэрбум төгрөг | |
| 5 | 2022-02-15 | Гол бараа материал үйлдвэрлэгдэж, Монгол руу ачуулахад бэлэн болсон байх | 36 тэрбум төгрөг | |

3.5 Туслан гүйцэтгэгчид төлбөл зохих үлдэгдэл төлбөр буюу 33,270,252,967 (гучин гурван тэрбум хоёр зуун далан сая хоёр зуун тавин хоёр мянга есөн зуун жаран долоон) төгрөгийн төлбөрийг Туслан гүйцэтгэгчийн Ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулах Ажил гүйцэтгэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн, гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан акт үйлдсэнээр дараах байдлаар төлж барагдуулна. Үүнд:

3.5.1 "Дохиолол холбооны цогц ажил"-ын хүрээнд хэрэглэгдэх тоног төхөөрөмж, материалууд Монголд тээвэрлэгдэн ирж, энэ тухай шалгалтын тайлан, гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан акт үйлдэгдсэн тохиолдолд – 10 тэрбум төгрөг;

3.5.2 "Дохиолол холбооны цогц ажил"-ын тоног төхөөрөмж бүрэн суурилагдаж, энэ тухай шалгалтын тайлан, гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан акт үйлдэгдсэн тохиолдолд – 10 тэрбум төгрөг;

3.5.3 "Дохиолол холбооны цогц ажил"-ын сургалт дуусч, нэгдсэн шалгалт хийгдэн, туршилтын хөдөлгөөн хийгдэж, энэ тухай тайлан үйлдэгдэн, гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан акт үйлдэгдсэн тохиолдолд – 10 тэрбум төгрөг;

3.5.4 "Дохиолол холбооны цогц ажил"-ыг улсын комисст хүлээлгэж өгсний дараа – 3,270,252,967 төгрөг;

3.6 Захиалагчаас Туслан гүйцэтгэгчид төлбөл зохих төлбөрийг энэхүү гэрээний 3.1 дэх заалтад дурдсан бичиг баримтыг үндэслэн, урьдчилгаа төлбөрийн хувьд гэрээний 3.3 дахь заалтыг хангуулсны үндсэн дээр Туслан гүйцэтгэгчийн ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийг үндэслэн даруй барагдуулах арга хэмжээг Захиалагчийн зүгээс авч хэрэгжүүлнэ.

3.7 Захиалагчаас Туслан гүйцэтгэгчид шилжүүлэх гэрээний төлбөрийг дараах дансанд шилжүүлнэ. Үүнд:

Хүлээн авагчийн банк: БНСУ-ын банкны KEB HANA BANK, GURO DIGITAL BRANCH / Tel:+82-28631111 /

Хүлээн авагчийн дансны дугаар: 149-890078-38538

Хүлээн авагчийн нэр: BYUCKSAN POWER CO.,LTD

Хүлээн авагчийн банкны SWIFT Code: KOEXKRSE

Дээрх дансанд төлбөрийг ам.доллаар гүйцэтгэх бөгөөд энэхүү гэрээний 2.2 дахь заалтад дурдсан ам.долларыг төгрөгт шилжүүлэх ханшийг баримтална.

3.8 Туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын аж ахуй нэгжийг туслан гүйцэтгэгчээр авч ажиллуулсан тохиолдолд гүйцэтгэлийн төлбөрийг Захиалагч болон Туслан гүйцэтгэгч нарын хоорондын зөвшилцлийн дагуу Захиалагч Монгол Улсын туслан гүйцэтгэгч компанитай санхүүжилтийн гэрээ байгуулсны үндсэн дээр шилжүүлэх ба Туслан гүйцэтгэгчийн зөвшөөрсний дагуу Түншлэгчид төлбөрийг бас шилжүүлж болно.

3.9 Захиалагч нь гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл энэхүү гэрээний 3.4 ба 3.5 дахь заалтад заасны дагуу гүйцэтгэлийн төлбөрийг төлөх бүрт гүйцэтгэлийн төлбөрийн үнийн дүнгийн 5 хувийг суутган авах ба улсын комисс хүлээж авсны дараа 2,5 хувийг, үлдэгдэл 2,5 хувийг чанарын баталгаат хугацаа дуусгавар болсны дараа Туслан гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн чөлөөлнө.

## 4. СУРГАЛТ, ДАДЛАГАЖУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

4.1 Туслан гүйцэтгэгч нь Захиалагчийн Тавантолгой-Зүүнбаян төмөр замын дохиолол холбооны засвар үйлчилгээний ажилчид, инженерүүдийн сургалтыг зохион байгуулах ба энэ ажлын хөлс нь энэхүү гэрээний 2.7 дахь заалтад дурдсан үнэд багтсан болно.

4.2 Туслан гүйцэтгэгчийн Захиалагчид үзүүлэх сургалт, дадлагажуулалтын үйлчилгээний сургалтын чиглэл, сургалтын хөтөлбөр, сургалтын агуулга, сургалтын төлөвлөгөө, талуудын эрх үүрэг, сургалтын гарын авлага, өмчлөл зэрэг асуудлуудыг “Сургалт, дадлагажуулалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ээр Талууд харилцан тохиролцож, энэхүү гэрээнд хавсаргасан ба энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

4.3 Туслан гүйцэтгэгч нь дээр дурдсан “Сургалт, дадлагажуулалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-гээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хангалтгүй биелүүлсэн тохиолдолд торгууль хүлээх ба энэ нь гэрээний төлбөрийн 5% хүртэл байна.

## 5. ЧАНАРЫН БАТАЛГААТ ХУГАЦААНД ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

5.1 Туслан гүйцэтгэгчийн үзүүлэх чанарын баталгаат хугацааны үйлчилгээ

5.1.1 Гэрээний судалгаа: Захиалагчийн шаардлагыг бүрэн хангасан чанартай системийг суурилуулахын тулд гэрээний бичиг баримтад заасан ерөнхий нөхцөл, техникийн нөхцөл болон чанарын шаардлагад нийцсэн тухай судалгааг явуулна.

5.1.2 Зураг төслийн удирдлага: Энэхүү ажил нь Захиалагчийн тогтоосон шаардлагыг хангасан гэдгийг батлахын тулд системийн зураг төслийг боловсруулж баталгаажуулснаар тодорхой хугацаанд, бүтээмж сайтай системийг бүрэн байгуулж дуусгах зорилготой болно.

5.1.3 Баримт бичиг болон материалын удирдлага: ISO 9001 олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, эрхлэн гаргасан бүх бичиг баримтыг үр ашигтайгаар удирдаж хадгалахыг зорьж ажиллана.

5.1.4 Худалдан авах ажиллагаа: Бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг тогтоосон журмын дагуу хийж гүйцэтгэх бөгөөд бүтээмж сайтай системийг бий болгох бараа материалаар хангаж ажиллана.

5.1.5 Ажлын графикт төлөвлөгөө: Төмөр замын дохиолол холбооны системийн чанарт шууд нөлөө үзүүлэхүйц зураг төсөл, үйлдвэрлэл, угсралт суурилуулалт, туршилт зэрэг ажлын графикт төлөвлөгөөг сайтар тооцоолж, эдгээр ажлуудын гүйцэтгэлийг биелүүлснээр системийн чанарын шаардлагыг бүрэн хангаж ажиллана.

5.1.6 Шалгалт, туршилт: Шалгалт болон туршилтыг үйлдвэрлэл, угсралт суурилуулалт зэрэг энэхүү ажлын бүх үйл явцаар дамжуулан техникийн шаардлага, зураг төсөл, Захиалагчийн шаардлагуудад нийцэж буй эсэхийг нягтлан чанарын баталгааг гаргах зорилгоор ажиллана.

5.1.7 Шаардлага хангаагүй бараа материалын удирдлага: Журмаар тогтоосон чанарын шаардлагад нийцээгүй бараа бүтээгдэхүүнийг ашиглах мөн угсарч суурилуулахаас сэргийлж ажиллана.

5.2 Туслан гүйцэтгэгчээс чанарын удирдлагыг хэрэгжүүлж ажиллах:

5.2.1 Туслан гүйцэтгэгч нь дэвшилтэт технологи болон хэрэглэгчийн чанарын шаардлагыг хангахын тулд Түншлэгчийн чанарын үзүүлэлтийг үндсэн зарчим болгох бөгөөд чанарын удирдлагын зорилт нь тохирох хугацаанд бүрэн бүтэн бүтээгдэхүүнийг нийлүүлнэ. Үүнийг биелүүлэхийн тулд Туслан гүйцэтгэгч нь Захиалагчийн чанарын удирдлагын журамд үндэслэн чанарын системийг боловсруулан хэрэгжүүлнэ.

5.2.2 Чанарын удирдлагын систем нь төмөр замын дохиолол холбооны системийг үр бүтээмжтэй байгуулахын тулд зураг төсөл, худалдан авалт, үйлдвэрлэл, системийн угсралт суурилуулалт болон туршилт зэрэг төслийн бүх үйл явцыг Захиалагчаас тогтоосон шаардлагад нийцүүлэн баталгааг гаргаж удирдахын тулд төлөвлөгөө болон дэс дараалллыг боловсруулж зөв хуваарилж ажиллах зорилготой.

5.3 Туслан гүйцэтгэгчээс чанарын баталгаат хугацаанд засвар үйлчилгээ үзүүлэх

5.3.1 Хугацаа: Туслан гүйцэтгэгчээс Захиалагчид нийлүүлсэн бүх тоног төхөөрөмж болон угсралтын ажлын чанарын баталгаат хугацаа нь комисст хүлээлгэж өгсөн өдрөөс хойш 4 жилийн хугацаатай байна.

5.3.2 Доголдол арилгах: Системд доголдол гарсан тохиолдолд систем ашиглагчаас тухайн мэдээллийг хүлээн авсан даруй учир шалтгаанд анализ хийж яаралтай хариу арга хэмжээг боловсруулна.

5.3.3 Чанарын баталгааны барьцаа төлбөр: Туслан гүйцэтгэгч нь аюулгүй ажиллагаа зүгшрүүлэлт, тохируулгын хугацаа болон доголдол, зөрчлийн чанарын баталгаат хугацаанд Туслан гүйцэтгэгч талын хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5% хувийг гэрээний 3.9-д заасан хугацаа дуусах хүртэл барьцаа болгон байршуулна.

5.4 Үүссэн зөрчил, доголдлыг Туслан гүйцэтгэгчээс арилгаж ажиллах:

5.4.1 Туслан гүйцэтгэгч нь энэхүү бүлгийн бүх агуулгад орсон аюулгүй ажиллагаа зүгшрүүлэлт тохируулгын хугацаа 1 жил, чанарын баталгаат хугацаа 3 жил, нийт 4 жилийн хугацаанд хийх засвар үйлчилгээнд тохирох үр бүтээмжтэй дэлгэрэнгүй шийдэл болон төлөвлөгөөг боловсруулж санал болгоно.

5.4.2 Чанарын баталгаат хугацаанд тоног төхөөрөмж тус бүрт тогтмол үзлэг хийж, доголдлыг засварлах, яаралтай арга хэмжээг авах, хүний нөөц зэрэг бодит засвар үйлчилгээ үзүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөг гаргах бөгөөд үүнийгээ баталгаажуулан төлөвлөгөөг хүргүүлнэ.

5.4.3 Туслан гүйцэтгэгч нь чанарын баталгааны засвар үйлчилгээний үзүүлэх төлөвлөгөөнд системийн суурилуулалт болон шилжүүлэх тухай төлөвлөгөөг Захиалагчийн дотоод засаг захиргаанд шаардагдах хоног хугацааг харгалзан үзэж урьдчилан хүргүүлэх бөгөөд Захиалагчаар батлуулна.

5.4.4 Туслан гүйцэтгэгч нь чанарын баталгаат хугацаанд системд асуудал гарсан тохиолдолд нэн даруй засварлах болон солих ёстой бөгөөд зөрчил, доголдол арилгасан талаар шалгуулж шийдвэрлүүлнэ.

5.4.5 Засвар үйлчилгээний ажилтнууд дунд Захиалагчийн зүгээс ажлын ур чадвар хангалтгүй гэж үзсэн тохиолдолд Туслан гүйцэтгэгч нь Захиалагчтай зөвшилцөн дээрх ажилтныг солих арга хэмжээг авна.

5.4.6 Чанарын баталгаат хугацаанд Туслан гүйцэтгэгчийн нийлүүлсэн тоног төхөөрөмж,

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Захиалагчийг төлөөлж:.................................... Туслан гүйцэтгэгчийг төлөөлж:..........................

бараа материал зэрэгт доголдол илэрч, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд Туслан гүйцэтгэгчийн зардлаар арилгах бөгөөд гол шалтгаан, хариу арга хэмжээний жагсаалтад дүн шинжилгээ хийж, хяналт үзлэгийг жилд 2 удаа хийнэ.

5.4.7 Туслан гүйцэтгэгч нь ажиллаж буй төхөөрөмжийн ажиллагааг зогсоолгүйгээр үзлэг шалгалт хийх аргачлал мөн төхөөрөмж тус бүрт тогтмол үзлэг хийх давтамж, үзлэг хийх аргачлал, төрөл тус бүрээр хэм хэмжээний үзүүлэлт гэх мэт ашиглалт засвар үйлчилгээний шийдлийг тодорхой боловсруулж санал болгож, саатал, доголдол илэрсэн тохиолдолд сэргээх, засварлах дэс дараалльг гаргаж өгнө.

5.4.8 Туслан гүйцэтгэгч нь тухайн ажлын зураг төслийг дахин боловсруулах, засах болон солих зэргээр Захиалагч хүлээж авах зарчим болон заасан цаг хугацаанд багтаан доголдлыг арилгана. Засварласан тоног төхөөрөмжид ч гэсэн чанарын баталгааны хугацаа адил үйлчилнэ.

## 6. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 Гэрээний 3.1, 3.3, 3.4, 3.5 болон 3.6 дахь заалтуудад заасан шаардлагыг хангасан тохиолдолд гэрээний төлбөрийг төлж барагдуулна.

6.2 Монгол Улсын хууль тогтоомж, Захиалагч болон Ерөнхий гүйцэтгэгч нарын хооронд байгуулагдсан “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд бүтэц, дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбооны систем, эрчим хүч, гүүрийн барилгын ажил, зураг төсөл гүйцэтгэх гэрээ”-нд заасан үндэслэлээр, эсхүл энэ Гэрээний 3.1, 3.3 болон 3.6 дахь заалтуудад заасан шаардлага хангагдаагүй тохиолдолд гэрээний төлбөрийг олгохоос татгалзах, гэрээний төлбөр төлөх хугацааг хойшлуулах эрхтэй.

6.3 Энэхүү гэрээний нөхцөлийн биелэлтэд Захиалагчийн Санхүү, эдийн засгийн газар болон Төслийн нэгж хяналт тавьж, биелэлтийг хангаж ажиллана.

6.4 Ерөнхий гүйцэтгэгч болон Туслан гүйцэтгэгч нарын хооронд байгуулагдсан Ажил гүйцэтгэх гэрээний төлбөр төлөхөөс бусдаар уг гэрээгээр зохицуулагдсан бусад асуудлаар аливаа эрсдэл, хариуцлага болон үүрэг хүлээхгүй.

6.5 Захиалагч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, түүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн энэ гэрээ цуцлагдсан бол туслан гүйцэтгэгчид учирсан хохирлыг хариуцна.

## 7. ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

7.1 Туслан гүйцэтгэгч нь Ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээгээр хүлээсэн үүрэг болон энэхүү гэрээний 4 ба 5 дугаар бүлэгт хүлээсэн үүргийг цаг хугацаанд нь биелүүлж ажиллана.

7.2 Туслан гүйцэтгэгч нь Захиалагчаас энэхүү гэрээгээр тохиролцсон төлбөрөө тохиромжтой цаг хугацаандаа авч чадахгүй байх тохиолдолд хугацаандаа төлөхийг шаардах эрхтэй бөгөөд гүйцэтгэлтэй холбоотой гаргасан ямарваа нэг мэдээлэл болон тайлан, нэхэмжлэлийн үнэн зөвийг хариуцна.

7.3 Гэрээний 3.3, 3.4 дахь заалтуудад заасан шаардлагыг хангасан тохиолдолд төлбөрийг гэрээнд заасан хугацаанд олгохыг шаардах эрхтэй.

7.4 Төлбөр төлөхтэй холбогдуулан Захиалагчаас шаардсан баримт бичгийг гаргаж өгөх

үүрэгтэй.

7.5 Захиалагчийн Туслан гүйцэтгэгчид төлбөл зохих төлбөр ажлын 14-өөс хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд Захиалагч нь энэхүү тогтоосон өдрөөс хойш хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн 0,2 хувиар алданги төлнө. Энэхүү гэрээний 3.5 дахь заалтад дурдсан төлбөрийн хувьд 60-аас дээш хоногоор хугацаа хэтэрсэн тохиолдолд алданги тооцох ба аль болохоор алданги тооцохгүй байх арга замыг Талууд эрэлхийлж ажиллана.

7.6 Дээрх 7.5 дахь заалтад дурдсан нөхцөл байдал үүсч, шийдвэрлэгдэж чадахгүй болон шийдвэрлэх хүчин чармайлт гаргахгүй байгаа тохиолдолд Туслан гүйцэтгэгч нь ажлыг зогсоох эрхтэй.

7.7 Туслан гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, түүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн энэ гэрээ цуцлагдсан бол Захиалагчид учирсан хохирлыг хариуцна.

## 8. БУСАД

8.1 Цогц гэрээ: Энэхүү гэрээ нь Ерөнхий гүйцэтгэгч болон Туслан гүйцэтгэгч нарын хооронд “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулагдсанаар цогц болно. Тус гэрээгээр гүйцэтгэгдэх Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын “Дохиолол холбооны цогц ажил” –ын төлбөрийг төлөхтэй холбоотой бүхий л нөхцөл, журмуудыг энэхүү гэрээ агуулсан ба энэхүү гэрээ байгуулагдахаас өмнө Талуудын хооронд өмнө бичгээр эсхүл амаар тохиролцсон бүхий л тохиролцоо, амлалтууд хүчингүй болно.

8.2 Ерөнхий гүйцэтгэгч болон Туслан гүйцэтгэгч нарын хооронд “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулагдаж, цогц гэрээ болсоноор “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний холбогдох заалтуудтай нийцүүлэхээр энэхүү гэрээнд тусгагдсан заалтууд үйлчилж эхэлнэ.

8.3 Гэрээний бусад зүйл заалт хүчин төгөлдөр байх: Энэхүү Гэрээний аль нэг заалт нь хүчингүй болсон тохиолдолд гэрээний бусад заалтууд үргэлжлэн хүчин төгөлдөр байна.

8.4 Харилцаа, холбоо:

8.4.1 Талуудын хооронд энэхүү гэрээгээр гаргаж өгөх шаардлагатай, зөвшөөрөгдсөн бүхий л мэдэгдэл, шаардлага, бусад холбоо харилцаа нь бичгээр хийгдэх бөгөөд тэдгээрийг хүлээн авагчид бие хүнээр, эсхүл шуудангаар тус тус хүргүүлнэ.

8.4.2 Энэхүү Гэрээний зорилгоор Талуудын доорхи хаяг, факсын дугааруудыг ашиглана. Үүнд:

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Захиалагчийг төлөөлж: ...................................... Туслан гүйцэтгэгчийг төлөөлж:......................................

MONGOLIAN RAILWAY

KOREA NATIONAL RAILWAY

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төслийн нэгжийн дарга Ж.Энхбаяр, Санхүү, эдийн засгийн газрын дарга Б.Энэрэлт
Утас: 7000-6622, 7010-6655
Э-мэйл хаяг: info@mtz.mn
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол, Нарны зам-62 Юнион бюлдинг А блок, 7 давхар.

"Солонгосын Үндэсний Төмөр зам"-ын Монгол дахь салбарын туслах менежер Л.Долгоржав
Утас: БНСУ-дахь "Korea National Railway"-ын дугаар 82-42-607-3422, 95073887, 91108487
Э-мэйл хаяг: www.kr.or.kr, y811@naver.com, dolgorjavl@gmail.com
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 04230, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам-62, Юнион бюлдинг А блок, 7 давхар .

8.4.3 Талуудын хаяг өөрчлөгдсөн тохиолдолд тухайн тал нөгөө талдаа хаяг өөрчлөгдсөн тухай нэн даруй мэдэгдэн шинэ хаягаа өгөх үүрэгтэй.

## 9. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

9.1 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, тахал, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг, Монгол Улсын эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэрийн улмаас гэрээний үүргээ биелүүлэх эсхүл төслийг үргэлжлүүлэх боломжгүй болох, санхүүжилт зогсох зэрэг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд үүрэг гүйцэтгэхэд саад учирсан, эсхүл гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг тухайн нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлуулах бөгөөд уг нөхцөл байдал давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал 60-аас дээш хоног үргэлжилсэн тохиолдолд талууд гэрээг цуцлах эрхтэй.

## 10. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

10.1 Талуудын хооронд энэхүү Гэрээнээс үүдэн гарсан аливаа маргаан, шаардлага, эсхүл санал зөрөлдөөнийг талууд зөвшилцлийн аргаар шийдвэрлэхийн төлөө бүхий л шаардлагатай арга хэмжээг авна. Талууд маргааныг шийдвэрлэхийн тулд зуучлагч хөлсөлөн авч болно.

10.2 Хэрэв маргааныг гэрээний 10.1-д заасны дагуу шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 11. ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ, ГЭРЭЭНИЙ ХУВЬ, ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

11.1 Гэрээг Монгол Улсын хуулиар тайлбарлаж зохицуулна.

11.2 Гэрээг Монгол хэлээр үйлдэв. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь Монгол хэл дээр байна.

11.3 Гэрээг хоёр хувь үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулах ба хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

11.4 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй, тусгаагүй харилцааг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Захиалагчийг төлөөлж:.............................. Туслан гүйцэтгэгчийг төлөөлж:..............................

MONGOLIAN RAILWAY

KOREA NATIONAL RAILWAY

11.5 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт нь Талуудын төлөөлөх эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, баталгаажсанаар хүчин төгөлдөр болно.

11.6 Талууд нь харилцан гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн энэхүү гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

11.7 Энэ гэрээг байгуулж, гэрээ хэрэгжих явцад талуудын хоорондын харилцаа болон аливаа мэдээллийг солилцохдоо Монгол Улсын холбогдох хуулийн хүрээнд нууцлалыг хадгална.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ,
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| **ЗАХИАЛАГЧИЙН ТӨЛӨӨЛЖ:** | **ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** |
|---|---|
| "МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ | "СОЛОНГОСЫН ҮНДЭСНИЙ ТӨМӨР ЗАМ"-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ КИМ ХАН ЁОНГ (KIM HAN YOUNG), ТҮҮНИЙГ ТӨЛӨӨЛЖ МОНГОЛ ДАХЬ САЛБАРЫН ЗАХИРАЛ |
| ............................ | ............................................ |
| **О.БАТНАСАН** | **КИМ СОН ЮНГ (Kim Seong Ryong)** |

УЛААНБААТАР ХОТ МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ ТӨХК 1117144653

Korea National Railway Солонгосын Үндэсний Төмөр зам

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

MONGOLIAN RAILWAY

KOREA NATIONAL RAILWAY

“Монголын төмөр зам” ТӨХК болон<br>
“Солонгосын үндэсний төмөр зам” байгууллагайн<br>
хооронд 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр<br>
байгуулсан СГ-21/110-109/05 дугаартай<br>
Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн<br>
төмөр замын Дохиолол холбооны системийн<br>
зураг төсөл, программ хангамж боловсруулах,<br>
тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт суурилуулалтын<br>
цогц ажлын гэрээний Хавсралт

## СУРГАЛТ, ДАДЛАГАЖУУЛАЛТЫН ГЭРЭЭ

| | |
|---|---|
| 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр | Улаанбаатар хот |

### 1. Нийтлэг үндэслэл

1.1 **Гэрээний зорилго:** Энэхүү гэрээ нь 2021 оны 9 дүгээр сарын 24-ны өдөр “МТЗ” ТӨХК болон “Солонгосын Үндэсний Төмөр Зам” байгууллагын хооронд байгуулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын “Дохиолол холбооны системийн зураг төсөл, программ хангамж боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт суурилуулалтын цогц ажлын гэрээ” (цаашид “Дохиолол холбооны цогц ажлын гэрээ” гэх) -ний 4 дүгээр бүлэгт заасан Хавсралт гэрээ бөгөөд Туслан гүйцэтгэгч тал болох “Солонгосын Үндэсний Төмөр Зам” нь Захиалагч тал болох “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замд ажиллах дохиолол холбооны засвар үйлчилгээний ажилчид, инженерүүдийн сургалтыг зохион байгуулах тухай гэрээ болно.

1.2 “Дохиолол холбооны цогц ажил”-ын Туслан гүйцэтгэгч “Солонгосын Үндэсний Төмөр Зам” байгууллага болон Түншлэгч “Byucksan power Co., Ltd” байгууллага нь Захиалагч талын засвар үйлчилгээний ажилчид, инженерүүдийг мэргэшүүлэх болон дадлагажуулалтын сургалтыг /гадаад болон дотоодод/ хийхдээ Талуудын хооронд байгуулагдсан .............. тоот Дохиолол холбооны цогц ажлын гэрээний 4.2-д заасны дагуу холбогдох зардлыг Туслан гүйцэтгэгч бүрэн хариуцна.

1.3 Сургалтыг зохион байгуулахдаа “МТЗ” ТӨХК-ийн баталсан техникийн ерөнхий шаардлагад уялдуулан хийнэ.

### 2. Сургалтын чиглэл

2.1 Сургалтын хөтөлбөр нь дараах үндсэн хоёр чиглэлтэй байна.

2.1.1 Ашиглалтын чиглэлээр: холимог ба ашиглалт

2.1.2 Засвар үйлчилгээний чиглэлээр: RAMS үзүүлэлтийг хангасан түвшин бүхий, аюулгүй гүйцэтгэлтэй үйл ажиллагааны систем болон функцуудын боломжтой, тохирсон байдлыг бүрдүүлэх.

## 3. Сургалтын үр дүн, зорилго

3.1 Сургалтын хөтөлбөрийг дараах үр дүнд хүрэх зорилгоор боловсруулна.

- Туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын үр дүн буюу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбооны системийг захиалагч цаашид бие даан ашиглах, хөгжүүлэхэд өөрийн инженер технологийн ажилчдыг сургах, мэргэшүүлэх зорилгоор Туслан гүйцэтгэгчээс сургалтын үйлчилгээг авч байгаа бөгөөд Туслан гүйцэтгэгч нь Захиалагчийг дээрх зорилгоо биелүүлэхэд чиглэсэн сугргалтын цогц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Туслан гүйцэтгэгч Захиалагчид зориулсан цогц сургалтыг зохион байгуулсны үр дүнд Захиалагчийн инженер, техник, технологийн мэргэжилтнүүд дараах ур чадварийг эзэмшсэн байна. Үүнд:
  - дохиолол холбооны системийн ашиглалт болон засвар, үйлчилгээний үндсэн технологи, дүрэм, журам, үйл ажиллагааны үндсэн горимыг ойлгох,
  - дохиолол холбооны системийн ашиглалт, засвар, үйлчилгээг хийх,
  - дохиолол холбооны системийн ашиглалт, засвар, үйлчилгээг хийх ур чадварын бусдад зааж эзэмшүүлэх,
  - Дохиолол холбооны системийн программ хангамжийг өөрчлөх, хөгжүүлэх, боловсруулах,
  - Цаашид төслийн дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбооны системийг бие даан ашиглах

3.2 Сургалт нь Монгол Улсад болон дохиолол холбооны системүүд эсвэл эд ангиуд үйлдвэрлэгдсэн, инженерчлэгдсэн улсад явагдах ба сургалтыг Монгол, Англи хэл дээр явуулна.

## 4. Сургалтын хэлбэр

4.1 **Ажиллах зарчмын сургалт:**

- Сургалтыг танхимд лекцийн хэлбэрээр болон бодит байгууламж, үзүүлэн дээр дадлагажуулах сургалтыг явуулна.
- Сургалт нь холбогдох систем буюу функцийн үндсэн дээр зарчим ба ойлголтыг тайлбарлаж системийн ашиглалтын нэгдлийн үндсэн мэдлэгийг олгоно.

4.2 **Ашиглалтын сургалт:**

- Сургалт нь ангид лекц хэлбэрээр болон практик сургалтыг хослуулж зохион байгуулна.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Захиалагчийг төлөөлж: ........................................ Туслан гүйцэтгэгчийг төлөөлж:........................................

- Практик цагийн сургалтын цаг нь хамгийн багадаа ашиглалтын сургалтын цагийг 2/3 харьцаатай байхаар сургалтыг зохион байгуулна.
- Ашиглалтын зааварчилгааны гарын авлагад орсон бүх сэдэв сургалтад орсон байна.

4.3 **Засвар үйлчилгээний бүх түвшний практик сургалт:**

- Сургалтын агуулга нь засвар үйлчилгээ ба засварын зохион байгуулалтад зориулагдсан хянах, засварлах буюу систем ба бүрэлдэхүүний хэсгийн төлөв рүү хандах, систем, бүрэлдэхүүн хэсэг, багаж хэрэгслийн зөв горимд байлгахад шаардлагатай бүх түвшний сургалтыг хамарна.
- Сургагч нь ирээдүйд ашиглах, суурилуулах системийн практик сургалтыг талбай дээр хийнэ. Туслан гүйцэтгэгч талын сургагч нь Захиалагчийн ажлын талбай дээр ирж хийнэ.

4.4 **Тестийн тоног төхөөрөмж, тусгай зориулалтын багаж хэрэгслийн практик болон гэмтлийг засах сургалт:**

- Сургалт нь ихэвчлэн ажлын талбай дээр практик сургалт байх боловч бүтэц бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлохын тулд тестийн тоног төхөөрөмж ба тусгай багаж хэрэгслүүдийн эд анги бүрийн талаар танхимын сургалтыг зохион байгуулна
- **Багш** нь сургалтад шаардлагатай материалуудыг ашиглаж (схемчилсэн бүдүүвч зураг, бүтцийн бүдүүвч зураг гэх мэт), бүх тестийн тоног төхөөрөмж ба тусгай багаж хэрэгслүүдийг ашиглах боломжтой байдлаар сургалтыг зохион байгуулна.
- **Багш** нь тестийн тоног төхөөрөмж ба тусгай багаж хэрэгсэл бүрийн засвар үйлчилгээний болон тохируулгыг практик дээр хийж үзүүлнэ.
- Тестийн шалгах хуудас, тоног төхөөрөмж, бүрэлдэхүүн хэсгүүдийн тестийн үйл явцыг болон "гэмтэл засах" үйл явцыг тодорхой харуулсан практик үзүүлэнг хийнэ.

4.5 **Системүүдийн нэгдсэн сургалт:**

- Сургалтыг ихэвчлэн ажлын талбай дээр явуулах бөгөөд энэ нь практик сургалт байна.
- Туслан гүйцэтгэгчийн Сургагч-багш нь Хяналтын шалгах хуудас, Системүүдийн нэгдсэн тестийн журам ба Гэмтэл засварлах аргачлалын хамт нэгтгэн үзүүлэх сургалтыгхийнэ.
- Энэхүү сургалтаар төмөр замыг бүхэлд нь ба төрөл бүрийн бүхий л системүүдийн харилцаа уялдааг хангасан сургалт байна.
- Багш нь энэхүү сургалтаараа бүх үйл ажиллагааны хувьд өмнөх засвар үйлчилгээний гүйцэтгэл, нэгдсэн системийн туршилтын дараа уг системийн төлвийг үнэлэх, батлах чадвартай болгож өгнө.

## 5. Сургалтыг төлөвлөгөө

5.1 Доорх хүснэгтэд сургалтын шаардлагатай хэмжээг хүн-цагаар үнэлнэ.

5.2 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дохиолол холбооны системийн зураг төсөл, программ хангамж боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт суурилуулалтын цогц ажлын гэрээ байгуулагдмагц доорх сургалтын төлөвлөгөөнд хамрагдах эхний ээлжийн сургалтыг зохион байгуулна.

5.3 Нэг өдрийн сургалтын цаг нь **5-7 цагаас** илүүгүй байна.

5.4 Сургалт болон түүнтэй холбоотой гарсан зардлыг Туслан гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

5.5 Сургалт бүрийг эхлэхээс **зургаан долоо хоногийн** өмнө Туслан гүйцэтгэгч тал сургалтын материалыг Монгол хэл дээр орчуулан боловсруулж сургалтын материалын нэг хувийг, нэмэлт сургалтын материал болон цахим файлын хуулбарын хамт Захиалагчид хүргүүлнэ.

5.6 Дээрх материалыг Захиалагч хүлээн авч, хянаж баталгаажуулна.

**"Тавантолгой~Зүүнбаян" чиглэлийн төмөр замын Дохиоллын чиглэлээр хийгдэх сургалтын төлөвлөгөө /1-р үе шат/**

| Сургалтын өдрийн тоо | № | Сургалтын агуулга | Хүний тоо | Сургалтын цаг/өдөрт/ | Сургалтын нийт цаг | Хариуцагч |
|---|---|---|---|---|---|---|
| **1. Дохиолол хориглол, Хажуугийн илрүүлэгч систем** | | | | | | |
| 5 өдөр | 1 | Сургалтын зарчим, бүтэц | 22 | 5~7 | 5~7 | KNR |
| | 2 | Ур чадварын сургалт | | 5~7 | 10~14 | KNR |
| | 3 | Ашиглалтын аргачлалын сургалт | | 5~7 | 15~21 | KNR |
| | 4 | Доголдлын үед авах арга хэмжээ | | 5~7 | 20~28 | KNR |
| **2. Галт тэрэгний нэгдсэн удирдлагын төхөөрөмж** | | | | | | |
| 4 өдөр | 1 | Сургалтын зарчим, бүтэц | 22 | 5~7 | 25~35 | KNR |
| | 2 | Ур чадварын сургалт | | 5~7 | 30~42 | KNR |
| | 3 | Үйл ажиллагааны аргачлалын сургалт | | 5~7 | 35~49 | KNR |
| | 4 | Доголдлын үед авах арга хэмжээ | | 5~7 | 40~56 | KNR |
| **3. Суман шилжүүлэгч** | | | | | | |
| 2 өдөр | 1 | Сургалтын зарчим, бүтэц | 22 | 5~7 | 43~61 | KNR |
| | 2 | Ур чадварын сургалт | | 5~7 | 47~67 | KNR |
| | 3 | Ашиглалтын аргачлалын сургалт | | 5~7 | 51~73 | KNR |
| | 4 | Доголдлын үед авах арга хэмжээ | | 5~7 | 55~79 | KNR |
| **4. Замын хэлхээ ба гэрлэн дохио** | | | | | | |
| 2 өдөр | 1 | Сургалтын зарчим, бүтэц | 22 | 5~7 | 58~84 | KNR |

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Захиалагчийг төлөөлж: ................................ Туслан гүйцэтгэгчийг төлөөлж: ................................

MONGOLIAN RAILWAY

KOREA NATIONAL RAILWAY

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Ур чадварын сургалт | | 5~7 | 62~90 | KNR |
| | 3 | Ашиглалтын аргачлалын сургалт | | 5~7 | 66~96 | KNR |
| | 4 | Доголдлын үед авах арга хэмжээ | | 5~7 | 70~102 | KNR |
| **5. Гармын дохиоллын төхөөрөмж** | | | | | | |
| 2 өдөр | 1 | Сургалтын зарчим, бүтэц | 22 | 5~7 | 71~102 | KNR |
| | 2 | Ур чадварын сургалт | | 5~7 | 73~107 | KNR |
| | 3 | Ашиглалтын аргачлалын сургалт | | 5~7 | 74~107 | KNR |
| | 4 | Доголдлын үед авах арга хэмжээ | | 5~7 | 75~109 | KNR |

## "Тавантолгой~Зүүнбаян" чиглэлийн төмөр замын Холбооны чиглэлээр хийгдэх сургалтын төлөвлөгөө /2-р үе шат/

| Үе шат | № | Сургалтын нэр | Хүний тоо | Сургалтын цаг /өдөрт/ | Сургалтын нийт цаг | Хариуцагч |
|---|---|---|---|---|---|---|
| **1. TRS** | | | | | | |
| 3 өдөр | 1 | Сургалтын зарчим, бүтэц | 22 | 3~5 | 3~5 | KNR |
| | 2 | Ур чадварын сургалт | | 4~6 | 7~11 | KNR |
| | 3 | Үйл ажиллагааны аргачлалын сургалт | | 4~6 | 11~17 | KNR |
| | 4 | Доголдлын үед авах арга хэмжээ | | 4~6 | 15~23 | KNR |
| **2. Дамжуулалт, IP-PBX, Чанга яригч систем** | | | | | | |
| 4 өдөр | 1 | Сургалтын зарчим, бүтэц | 22 | 5~7 | 20~30 | KNR |
| | 2 | Ур чадварын сургалт | | 5~7 | 35~37 | KNR |
| | 3 | Ашиглалтын аргачлалын сургалт | | 5~7 | 30~44 | KNR |
| | 4 | Доголдлын үед авах арга хэмжээ | | 5~7 | 35~51 | KNR |
| **3. T-SCADA** | | | | | | |
| 3 өдөр | 1 | Сургалтын зарчим, бүтэц | 22 | 3~5 | 38~56 | KNR |
| | 2 | Ур чадварын сургалт | | 4~6 | 42~62 | KNR |
| | 3 | Ашиглалтын аргачлалын сургалт | | 4~6 | 46~68 | KNR |
| | 4 | Доголдлын үед авах арга хэмжээ | | 4~6 | 50~74 | KNR |
| **4. Хяналтын камер, зарлан мэдээлэх** | | | | | | |
| 3 өдөр | 1 | Сургалтын зарчим, бүтэц | 22 | 3~5 | 53~79 | KNR |
| | 2 | Ур чадварын сургалт | | 4~6 | 57~85 | KNR |

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Захиалагчийг төлөөлж:...................................... Туслан гүйцэтгэгчийг төлөөлж:......................

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Ашиглалтын аргачлалын сургалт | | 4~6 | 61~91 | KNR |
| | 4 | Доголдлын үед авах арга хэмжээ | | 4~6 | 65~97 | KNR |
| **5. Цахилгаан тоног төхөөрөмж** | | | | | | |
| 2 өдөр | 1 | Сургалтын зарчим, бүтэц | 22 | 2~3 | 67~100 | KNR |
| | 2 | Ур чадварын сургалт | | 3~4 | 70~104 | KNR |
| | 3 | Ашиглалтын аргачлалын сургалт | | 3~4 | 73~108 | KNR |
| | 4 | Доголдлын үед авах арга хэмжээ | | 2~3 | 75~111 | KNR |

- Сургалт зохион байгуулагдах газар нь 1,2-р шат нь БНСУ, 3-р шатыг Монгол Улсад зохион байгуулна.
- 3-р үе шатны сургалтад хамрагдах ажилтны тоо 50-аас доошгүй байна.
- Сургалтад хамруулах суралцагчдын хувьд 1, 2-р шатанд холбооны ашиглалт болон засвар үйлчилгээний ажилтнуудыг хамруулна.
- Сургалтын цаг нэг өдөрт 7 цагаас илүүгүй байхаар сургалтын агуулгад тохируулан уян хатан зохицуулах бөгөөд үе шат тус бүрийн сургалтын хугацаа нь 3 долоо хоног байна.
- Дээрх 3 долоо хоногийн хугацаанд явагдах 5 салбарын сургалтын өдрийн тоо болон сургалтын агуулга өөрчлөгдөж болно.
- Программд өөрчлөлт оруулах эрх буюу "source code"-ийг өөрчлөхтэй холбоотой сургалтанд 5 хүртэлх ажилтан хамрагдах ба сургалын төлөвлөгөөний 1,2,3-р үе шатны сургалтанд мөн адил суралцана.

## 6. Захиалагчийн эрх, үүрэг

6.1 Захиалагч суралцагчдын нэрсийг Туслан гүйцэтгэгчид хүргүүлнэ.

6.2 Засвар үйлчилгээний сургалтыг зохион байгуулах явцад хөдөлмөрийн аюулгүй байдлыг онцгой анхаарна.

6.3 Захиалагч тал Туслан гүйцэтгэгчийн сургалтууд нь батлагдсан хуваарийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавина.

6.4 Туслан гүйцэтгэгч талаас хүргүүлсэн сургалтын хөтөлбөрийг Захиалагч тал судалж, танилцан хоёр долоо хоногиин дотор хянаж батлаад Туслан гүйцэтгэгчид хариу илгээнэ.

6.5 Гадаадад сургалт зохион байгуулагдах үед Захиалагч тал сургалтад хамрагдах хүмүүсийн нэрсийн жагсаалт, холбогдох бичиг баримтуудыг Туслан гүйцэтгэгчид өгөх бөгөөд виз мэдүүлэхэд шаардлагатай холбогдох баримт бичгийг Туслан гүйцэтгэгч тал ЭСЯ-нд илгээнэ.

6.6 Захиалагч нь батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалт явуулж байгаа эсэх дээр хяналт тавьж, сургалтын чанарт шаардлага тавих эрхтэй.

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Захиалагчийг төлөөлж: .................................... Туслан гүйцэтгэгчийг төлөөлж:..................................

6.7 Гадаадад сургалтад хамрагдах суралцагчдыг Сургалт хариуцсан ахлах ажилтныг томилж, энэ тухай Туслах гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

6.8 Захилалагч нь гадаадад сургалтад хамрагдагч ажилтнууддаа Солонгос улсад санаатайгаар үлдэхгүй байх, хууль бус үйлдэл гаргахгүй байх талаар ажилтнууддаа мэдлэг мэдээлэл олгох ба үүнтэй холбоотой бүх хариуцлагыг Захиалагч хүлээнэ.

6.9 Захиалагч нь Туслан гүйцэтгэгчийн зохион байгуулах сургалтад хамрагдах инженер техникийн ажилчдаа бүрэн хамруулах, сургалтад идэвхтэй хамрагдах зэрэг зохион байгуулалтыг бүрэн хариуцна.

6.10 Туслан гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдлолд Дохиолол холбооны цогц ажлын гэрээнд заасан хариуцлага тооцох эрхтэй.

## 7. Туслан гүйцэтгэгчийн эрх үүрэг

7.1 Туслан гүйцэтгэгч нь Захиалагчтай зөвшилцсөнөөр БНСУ-д мэргэжлийн чиглэлээр инженерүүдийг магистр болон түүнээс дээш ахисан түвшинд суралцуулах түүнтэй холбоотой гарах зардлыг бүрэн хариуцна.

7.2 Туслан гүйцэтгэгч нь батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтын хуваарь гаргана.

7.3 Сургалт тус бүрийг эхлэхээс зургаан долоо хоногийн өмнө Туслан гүйцэтгэгч тал Монгол хэл дээр боловсруулсан сургалтын материал, нэмэлт сургалтын материал болон цахим файлын хуулбарын хамт батлуулахаар Захиалагчид хүргүүлнэ.

7.4 Бүх сургалтууд батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулагдах бөгөөд батлагдсан хөтөлбөрийн дагуу бух сургалтыг Туслан гүйцэтгэгч тал зохион байгуулж чадахгүй болсон тохиолдолд Дохиолол холбооны гэрээний 4.3-д заасны дагуу торгууль төлнө.

7.5 Гүйцэтгэгч тал нь үйлдвэрлэлийн туршилт болон гадаадад зохион байгуулсан сургалтад хамрагдсан инженер техникийн ажилтнуудад гэрчилгээ олгоно. Гэрчилгээ нь англи хэл дээр байна.

7.6 Туслан гүйцэтгэгч тал нь дотоодын сургалтад тоног төхөөрөмжийг хариуцан ажиллах, ашиглах Захиалагчийн ажилтнуудыг хамруулан сургаж, дадлагажуулах ба гэрчилгээ олгоно.

7.7 Программд өөрчлөлт оруулах эрх буюу "source code"-ийг захиалагчид шилжүүлэхтэй холбоотой сургалт зохион байгуулж, хамрагдсан инженер техникийн ажилтнуудад гэрчилгээ олгоно.

7.8 Программд өөрчлөлт оруулах эрх буюу "source code"-ийг Захиалагчид хүлээлгэн өгнө.

7.9 Гадаадад сургалтад хамрагдах суралцагчдын амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалыг Туслан гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

7.10 Гадаадад сургалтад хамрагдах суралцагчдын онгоцны тийз, байрлах байр, унаа,

хоолны зардлыг Туслан гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

7.11 Гадаадад сургалтад хамрагдсан суралцагчдыг онгоцны буудлаас ирэх болон буцах үеийн тээврийн асуудлыг Туслан гүйцэтгэгч тал хариуцна.

## 8. Өмчлөл

8.1 Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж Туслан гүйцэтгэгчийн боловсруулсан аливаа сургалтын материал, нэмэлт сургалтын материал, гарын авлага, судалгаа, тайлан зураг, график программ хангамж, программд өөрчлөлт оруулах эрх буюу "source code"-ийг болон бусад материал эд зүйл нь Захиалагчийн өмч болж үлдэнэ.

## 9. Сургалтын гарын авлага

9.1 Сургалтын материалыг Монгол ба Англи хэл дээр боловсруулж, батлагдсан хуваарийн дагуу Захиалагч талаар баталгаажуулна.

9.2 Захиалагч сургалтын гарын авлагыг хүлээж авснаас хойш зургаан долоо хоногийн дотор хянаж санал хүсэлтийг Туслан гүйцэтгэгчид хүргүүлнэ.

9.3 Захиалагчийн саналыг хүлээж авснаас хойш Туслан гүйцэтгэгч нь хоёр долоо хоногийн дотор "Сургалтын гарын авлага"-ыг шинэчлэн Захиалагчид хүргүүлж, шинэчилсэн гарын авлагыг Захиалагч нэг долоо хоногийн дотор хянаж батална.

9.4 Захиалагчийн баталсан "Сургалтын гарын авлага"-ын дагуу бүх сургалтууд зохион байгуулагдана.

9.5 Сургалтын гарын авлагыг шинэчлэх тохиолдолд сургалтын хугацааг сунгах эрхийг Гүйцэтгэгчид олгохгүй.

9.6 Сургалтын гарын авлагад батлагдсан бүх сургалтыг Туслан гүйцэтгэгч зохион байгуулж чадахгүй болсон тохиолдолд Туслан гүйцэтгэгч тал "№ .............тоот гэрээ"-нд заасны дагуу торгууль төлөх нөхцөл болно.

MONGOLIAN RAILWAY

KOREA NATIONAL RAILWAY

**ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..................................**О. БАТНАСАН**

**ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"СОЛОНГОСЫН ҮНДЭСНИЙ ТӨМӨР ЗАМ"-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ КИМ ХАН ЁОНГ (KIM HAN YOUNG) ТҮҮНИЙГ ТӨЛӨӨЛЖ МОНГОЛ ДАХЬ САЛБАРЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

..............................................................

**КИМ СОН ЮНГ (Kim Seong Ryong)**

Энэхүү гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаарах тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Захиалагчийг төлөөлж: ........................................ Туслан гүйцэтгэгчийг төлөөлж:..................................

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН
2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДРИЙН 315 ДУГААР ТУШААЛААР
БАЙГУУЛАГДСАН ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН ЗӨВЛӨМЖ

2020 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр | Дугаар № 153 | Улаанбаатар хот

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК,
"УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ" ХНН-д

Дэд ажлын хэсгийн 2020 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийг үндэслэн ЗӨВЛӨМЖЛӨХ нь:

1. Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар Төмөр Зам" нийгэмлэгээс ирүүлсэн саналыг үндэслэн Дохиолол холбооны системийн зураг төсөл, програм хангамж боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт суурилуулалт гүйцэтгэх багц ажлыг дараах нэр бүхий компаниар гүйцэтгүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

| № | Гүйцэтгэгч компани | Багц ажлын нийт дүн /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | **Korea National Railway** | **121 587 141 223 төгрөг**<br>/ Нэг зуун хорин нэгэн тэрбум таван зуун наян долоон сая нэг зуун дөчин нэгэн мянга хоёр зуун хорин гурван төгрөг/ |

2. Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар Төмөр Зам" хувь нийлүүлсэн нийгэмлэгийн дарга / Д. Жигжиднямаа /, "Монголын Төмөр Зам" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал / Р. Батсүх / - нарт холбогдох хууль тогтоомжид нийцүүлж, санхүүжилт шийдвэрлэгдсэнээр тухайн компанитай гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана уу. Гэрээт ажлын төлбөрийг гүйцэтгэлээр санхүүжүүлэх буюу банкны баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөр олгох асуудлыг гэрээнд тусгахыг зөвлөмжилж байна.

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА :
/......................................................./ Д. ГАНЗОРИГ

ГИШҮҮД :
/......................................................./ Б. МӨНХБАЯР
/......................................................./ Т. СҮХБОЛД
/......................................................./ П. БАДАМГАРАВ
/......................................................./ Н. ЦЭРЭНСАМБУУ
/......................................................./ Э. БАТБАЯР
/......................................................./ Ц. БАТЗУЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА :
/......................................................./ Б. ЭНЭРЭЛТ

**KOREA NATIONAL RAILWAY**
34618 242 Jungang-Ro, DongGu, Daejeon,Republic of Korea
TEL.+82-42-607-4065 FAX.+82-42-607-3289

17 September 2020

Mr. Jigiidnyamaa Damdinsuren
Chairman & CEO
Ulaanbaatar Railway Joint Stock Company
P.O Box-376, Seoul street-42
Ulaanbaatar-13
Mongolia

Subject: Submit documents about the signaling and communication of Tavantolgoi~Zuunbayan Railway project commercial price and technical documents

Dear Mr.Jigiidnyamaa

I am pleased to give your warm concern for our cooperation

About Tavantolgoi~Zuunbayan Railway project, I sent documents and estimated price about the signaling and telecommunication design and construction to you and your engineer before. I am sending you the final documents by supplementing the documents and the estimated price. Please refer to the attachment for the detail information. Final estimated price in below;

Final estimated price without customs duties and VAT : USD 36,945,357
(Based on exchange rate as of 19 August 2020. : MNT 105,270,252,967)
Final estimated price with customs duties and VAT : USD 42,671,887
(Based on exchange rate as of 19 August 2020. : MNT 121,587,141,223)

Thank you for your thoughtful cooperation. I look forward to working together.

Sincerely yours,

Kim, Seong-Ryong
Chief Representative of Mongolia office
Korea National Railway

Attachment. Documents about the Tavantolgoi~Zuunbayan Railway project

| 발 급 번 호<br>Issuance number | # 사 업 자 등 록 증 명<br>Certificate of Business Registration<br>( 법인사업자 )<br>( Corporate Taxpayer ) | 처 리 기 간<br>Processing time |
|---|---|---|
| 5014-805-8985-580 | | 즉 시<br>Immediately |

| | | |
|---|---|---|
| 상 호 ( 법 인 명 )<br>Name of company<br>(Business registration number) | 국가철도공단<br>Korea National Railway (305-82-13158) | |
| 사 업 자 등 록 번 호<br>Business registration number | 305-82-13158 | |
| 성 명 ( 대 표 자 )<br>Name of representative<br>(Resident(Corporation)<br>registration number) | 김한영<br>KIM HANYOUNG (165271-0005372) | |
| 주 민 ( 법 인 ) 등 록 번 호<br>Resident(Corporation)<br>registration number | 165271-0005372 | |
| 사 업 장 소 재 지<br>Business Address | 대전광역시 동구 중앙로 242(신안동, 국가철도공단)<br>Railway Twin Tower, 242, Jungang-ro, Dong-gu, Daejeon, Republic of Korea | |
| 개 업 일<br>Date of business commencement | 2004년(Year) 01월(Month) 01일(Day) | |
| 사 업 자 등 록 일<br>Date of business registration | 2004년(Year) 01월(Month) 05일(Day) | |
| 업 태<br>Business type | 건설업/전문, 과학 및 기술서비스업<br>Construction/Professional, scientific and technical activities | |
| 종 목<br>Business item | 지반조성 건설업, 도로건설업, 교량.터널 및 철도건설업, 수로.댐 및 급.배수시설 건설업,<br>Infrastructure Construction, Roads , Bridges, Tunnels & Railway Construction, Waterways, Dam and Water Supply Facilities Construction<br>연구개발업<br>Research and experimental development on other engineering | |
| 공 동 사 업 자<br>Joint business owner | 성명(법인명)<br>Name(Name of company) | 주민(사업자)등록번호<br>Resident(Business) registration No. |
| | 해당사항 없습니다 (No Data) | |

CONSULAR DIVISION
EMBASSY OF MONGOLIA

위와 같이 증명합니다.
I certify that above information is true and correct to the best of my knowledge and belief.

※ 위 내용은 발급일 현재 상황으로서 추후 변경될 수 있습니다.
This information is true as of the issuance date of this certification and but maybe subject to change in the future.

※ 영문 임의기재사항[상호, 성명(대표자), 업태, 종목, 상세주소]은 실체적 권리관계를 증명하는 효력이 없습니다.
Arbitrary data in English[name of company, name of representative, business type, business item, detail address] do not hold a power to prove the actual relationship of rights.

| | |
|---|---|
| 접 수 번 호 | 502280426118 |
| 담 당 부 서<br>Department | 민원봉사실<br>Taxpayer Service Center |
| 담 당 자<br>Staff in Charge | 김진희<br>KIM JIN HEUI |
| 연 락 처<br>Telephone No. | +082-42-229-8223 |

2021 년 3 월 25 일
Year Month Day

**대 전 세 무 서 장 (인)**
Head of Daejeon District Tax Office (Stamp)

국세청
National Tax Service

* 본 증명의 위·변조 여부는 발급일로부터 90일 이내 「국세청 홈택스(www.hometax.go.kr) 또는 모바일 홈택스 > 민원증명(증명발급) > 민원증명 원본확인」에서 발급번호로 확인, 또는 문서 하단의 바코드로 확인이 가능합니다.

Please be advised that forgery detection of this document can be performed with either of following methods.
1) anytime with the barcode at the bottom of the document, or
2) with the issuance number of the document at either Hometax website (www.hometax.go.kr) or mobile Hometax (Certificate of civil petition (certificate issued) > Check the original certificate of civil petition) within 90 days from the date of issuance.